



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/256

Хэрлэн сум

Явуулын хурлыг зохион байгуулах
зардалд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хангах тухай хуулийн 42.1.1, 42.1.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 23 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.9, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон Хэнтий аймгийн Засаг даргын хооронд төрийн зарим чиг үүргийг 2024 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний 2.36, 2.37, 2.44, Хүүхдийн хөгжил хамгааллын жилийн 2024 оны төлөвлөгөөний 4 дэх арга хэмжээг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын явуулын хурлыг зохион байгуулах зардалд 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний Хүүхдэд ээлтэй орон нутаг болно зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ